

АЙМГИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР

Нэг: Нийтлэг үндэслэл

Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны “Хөгжлийн хөтөч” хөтөлбөрт хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжин 6000-аас доошгүй ажлын байрыг бий болгохоор зорилт тавин ажиллаж байна.

Энэхүү зорилтын хүрээнд салбар хоорондын уялдааг хангах, иргэдийн мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх, хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, арга хэмжээг өргөжүүлэх бодлогыг хэрэгжүүлэх суурь хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага гарч байна.

Манай аймаг 2016 оны жилийн эцсийн байдлаар 61149 хүн амтай байгаагаас хөдөлмөрийн насны хүн 36258 үүнээс эдийн засгийн идэвхитэй хүн ам 28316 байна.

Аймгийн хэмжээнд ажил идэвхитэй эрж хайж байгаа иргэд 1480 байгаа бөгөөд эдгээр иргэдийн 50,4 хувь нь эмэгтэйчүүд байгаа нь нийт ажилгүйчүүдэд эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жин 2013 онтой харьцуулахад 8,4 хувиар өссөн байна. Харин насны бүлгээр авч үзвэл 25-45 насны ажилгүй иргэдийн 57,9 хувийг эзлэж байгаа нь хөдөлмөрийн насны ажиллах хүч болсон залуучуудын дунд ажилгүйдэл их байгааг харуулж байна.

Ажилгүйдлийн түвшин 2016 онд 4,6 хувьтай байсан бол 2017 оны эхний улирлын байдлаар 5,2 хувь болж өмнөх оныхоос 0,6 пунктээр өссөн байна. Энэ нь 2016 оны 08 сараас хойш ХЭДС-аас хэрэгжүүлж байсан төсөл хөтөлбөрийн санхүүжилт түр саатсантай холбоотой юм. Мөн Ерөнхий боловсролын сургууль болон МСҮТ-үүдийг төгсөөд ажил сургуульгүй үлдсэн, цэргээс халагдаж ирсэн, хорих ангиас суллагдсан, их дээд сургууль төгсөөд ажилгүй байгаа 400 орчим залуус хөдөлмөрийн зах зээлд жил бүр шилжин ирж байна.

Нийт ажилгүй иргэдийн 75,4 хувь нь дээд болон дунд мэргэжлийн боловсрол эзэмшсэн иргэд байна. Мөн малчин, мал бүхий иргэдийн 89,1 хувь нь хөдөлмөрийн насны буюу 15-60 насны иргэд байна.

Иймээс хүн амын хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдлийн асуудлыг шийдвэрлэхэд дээд, дунд мэргэжилтэй хүмүүсийн дунд ажилгүйдэл өндөр байгаа энэ онцлогийг харгалзан үзэх нь зүйтэй юм.

Үүнээс гадна манай аймгийн эдийн засгийн гол хөдөлгөгч хүч болж байгаа малчин, мал бүхий иргэдийн хэрэгцээнд нийцсэн тэдний орлогыг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр тодорхой арга хэмжээ авч ажиллах зайлшгүй шаардлага бий болж байна.

Сүүлийн жилүүдэд ажилгүйдэл, ядуурлыг бууруулахын тулд иргэдийг төрөл бүрийн мэргэжил олгох сургалтад хамруулах, гадаадад ажиллахад зуучлах, нийтийг

хамарсан ажилд хамруулах, түр болон байнгын ажлын байрыг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зэрэг олон ажлуудыг орон нутгийн төр захиргаа, Олон улсын байгууллагуудын дэмжлэгтэйгээр хийж гүйцэтгэсэн боловч хүн амын тооны хувьд ажилгүйдлын түвшин өндөр байна.

Иймд аймгийнхаа хөгжлийн нөхцөл байдлыг судлан, нөөц боломж, чадавхийг нь тодорхойлж, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн ур чадвар, мэргэжилтэй ажилтныг бэлтгэх, хүн амын орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх зорилгоор жижиг дунд үйлдвэрийг бодлогоор дэмжин хөгжүүлэх шаардлагатай байна.

Хоёр: Хөтөлбөр боловсруулах шаардлага

1. Тогтвортой ажлын байр бий болгосон зах зээлд өрсөлдөх чадвар бүхий жижиг дунд болон томоохон үйлдвэр манай аймагт маш цөөн /бараг байхгүй/
2. Хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээ шаардлагад нийцсэн өрсөлдөх чадвар сайтай, мэргэжлийн өндөр ур чадвартай боловсон хүчин дутмаг
3. Ажил олгогчид, ажил хайгч, зуучлагчийн уялдаа холбоо муу, мэдээлэл дутмаг, хөдөлмөрийн зах зээл дээр ажил олоход хүндрэлтэй иргэдийн тоо нэмэгдсэн
4. Хөдөлмөрийн зах зээлийн багтаамжийн нарийвчилсан судалгаа байхгүй
5. Малчдын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх тэдний эрүүл мэнд нийгмийн хамгааллыг сайжруулах, нийгмийн даатгалын тогтолцоонд хамруулах ажил хангалтгүй
6. Мэргэжилтэй ажилгүйчүүдийн тоо улам нэмэгдсэн

Гурав: Хөтөлбөр хэрэгжүүлэх зарчим

1. Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг адил тэгш, нээлттэй ил тод хүргэх
2. Ажил олоход хүндрэлтэй иргэдийн хөдөлмөрлөх тэгш эрх, адил боломжийг хангах
3. Нийгмийн түншлэлийг дэмжин, олон нийтийн оролцоонд тулгуурлах
4. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэн иргэний мэргэжлийн ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх
5. Иргэдийн хөдөлмөр эрхлэх боломж нөхцөлийг бүрдүүлэх, ажиллах хүчний хөдөлмөр эрхлэлтийн тогтвортой байдлыг хангах

Дөрөв: Хөтөлбөрийн зорилго

Иргэдийг өөрийн ур чадварын дагуу хүссэн мэргэжлээр нь түр сургалтанд хамруулж мэргэжил олгох, давтан сургах замаар мэргэжилтэн ажилтан бэлтгэж, орон нутгийн онцлогт нийцсэн үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлоготой уялдуулан хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, шинээр бий болгосон ажлын байрыг тогтвортой хадгалахад дэмжлэг үзүүлэн өрхийн орлогыг нэмэгдүүлэхэд оршино.

Тав: Хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ

5.1 Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн системийг боловсронгуй болгож мэдээлэлийн нэгдсэн сүлжээг өргөжүүлэн хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн нарийн мэргэжлийн мэдлэг ур чадвартай ажилтан бэлтгэх, давтан сургах зорилтын хүрээнд:

- Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санг боловсронгуй болгож, иргэн оршин суугаа газраасаа харьяалал үл харгалзан хөдөлмөр эрхлэлтийн арга хэмжээ, үйлчилгээнд хамрагдах боломжийг бүрдүүлэх;

- Хөдөлмөр эрхлэлтийн сургалтыг ажилгүй иргэн, ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн, ажил олоход хүндрэлтэй иргэн, сургууль завсардсан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамруулан үйлдвэрлэл дээрхи сургалт, мэргэжлийн болон давтан сургалт, явуулын болон зайны сургалтыг богино хугацаанд мэргэжлийн ур чадвар эзэмшүүлэн хөгжүүлэх замаар мэргэжлийн сургалтын төвүүд, орон нутгийн төр захиргааны байгууллагуудтай хамтран зохион байгуулах;

5.2 Аймгийн жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлоготой уялдуулан хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, шинээр бий болгосон ажлын байрыг тогтвортой хадгалахад дэмжлэг үзүүлэх зорилтын хүрээнд:

- Орон нутгийн онцлогт хэрэгцээнд нийцсэн жижиг, дунд үйлдвэрлэлийг шинээр бий болгох замаар ажлын байрыг нэмэгдүүлж, ажлын байрыг тогтвортой хадгалсан иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг урамшуулах;

- Бүх сумдад Сум хөгжүүлэх сан, ЖДҮДС, ХЭДС-аас төсөл хэрэгжүүлж, жижиг, дунд үйлдвэр, цех, нөхөрлөл, хоршоо, өрхийн үйлдвэрлэлийг шинээр байгуулах, өргөтгөхөд хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтээр дэмжин ажиллах;

- Ажил олоход хүндрэлтэй иргэдийг ажлын байраар хангах, бичил зээлийн хэлбэрээр дэмжин урамшуулах, нийтийг хамарсан ажилд зуучлан түр болон улирлын ажлын байраар хангах;

- Жижиг, дунд үйлдвэр, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн нөхөрлөл, бүлгийн зохион байгуулалтыг дэмжих, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг нь худалдан борлуулах механизмыг боловсронгуй болгох;

5.3 Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжин нийгмийн хамгааллыг сайжруулж, "Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах зорилтын хүрээнд:

- Цөөн малтай, орлого багатай малчдыг "Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр"-т хамруулах, малчин ажил олгогчийг дэмжин урамшуулах;

- Мал аж ахуйн үйлдвэрлэлийн түүхий эдийн нөөцөд тулгуурлан боловсруулах үйлдвэр, жижиг цехийг бүсчилсэн хэлбэрээр байгуулан хөдөөгийн хүн амын ажлын байрыг нэмэгдүүлэх

- Ажил олоход хүндрэлтэй малчдыг түүхий эд, үр бордоо, мал амьтан, тоног төхөөрөмж худалдан авахад зориулан дэмжлэг үзүүлэх;

5.4 Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцааны талаар бодлого боловсруулах, хэрэгжилтийг зохицуулахад хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлж, нийгмийн түншлэлийн байгууллагуудын идэвх, санаачлагыг дэмжих зорилтын хүрээнд:

- Хөдөлмөр эрхлэлтийн удирдлага, бодлого зохицуулалтад иргэдийн оролцоог нэмэгдүүлэн, төр-хувийн хэвшил, нийгмийн түншлэгч байгууллагуудын санал санаачлага, хамтын ажиллагааг дэмжиж, тэдгээрийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;

- Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт болон салбар, орон нутгийн түншлэлийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, нийгмийн түншлэгчид, бусад холбогдох талуудтай хамтран ажиллаж, тэдгээрийн оролцоог хангах; - Зохистой хөдөлмөрийг дэмжих замаар бүтээмжтэй, аюулгүй ажлын байрыг бий болгон, тогтвортой хадгалж байгаа ажил олгогчийг зээлийн бодлогоор дэмжих, урамшуулах тогтолцоо бий болгох;

Зургаа: Хөтөлбөрийн хэрэгжилтийн хугацаа, удирдлага зохион байгуулалт, санхүүжилт

6.1 Хөтөлбөр хэрэгжүүлэх хугацаа:

Хөтөлбөрийг 2017-2020 онд хэрэгжүүлнэ.

6.2 Удирдлага зохион байгуулалт:

6.2.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг эдийн засаг нийгмийн бусад хөтөлбөрүүдтэй уялдуулан зохицуулах, хэрэгжүүлэх ажлыг аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөл удирдлага зохион байгуулалтаар ханган хяналт тавьж, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, аймгийн Ажил олгогч эздийн холбоо, Үйлдвэрчний эвлэлийн байгууллагуудын оролцоотойгоор хэрэгжүүлнэ.

6.2.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг улс, орон нутгийн төсөвт тусгаж хэрэгжүүлнэ.

6.3 Санхүүжилт:

Хөтөлбөрийн санхүүжилт дараах эх үүсвэрээс бүрдэнэ.

- Төвлөрсөн болон орон нутгийн төсвөөс олгох хөрөнгө
- Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
- Олон улсын байгууллагын зээл тусламж
- Ажилгүйдлийн даатгалын сан
- Сум хөгжүүлэх сан
- Банкны зээл

- Орон нутагт бий болсон зээлийн сангууд
- Аж ахуйн нэгж, иргэд, ТББ-ийн санаачлагаар бүрдсэн тусламж хандивын хөрөнгө

Долоо: Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт, дүгнэх шалгуур үзүүлэлт

7.1 Хөтөлбөрийн хяналт- шинжилгээ үнэлгээ

- Хөтөлбөрийн хяналт шинжилгээ үнэлгээнд төрийн бус байгууллага, иргэдийг оролцуулах

7.2 Хөтөлбөрийн хэрэгжилтийг дараах шалгуур үзүүлэлтээр дүгнэнэ.

- o Шинээр бий болсон ажлын байрны тоо
- o Ажилгүйдлийн түвшиний бууралт
- o Ажилд зуучилсан иргэдийн тоо
- o Хөдөлмөр эрхлээгүй иргэнийг орон нутагтаа шаардлагатай байгаа мэргэжлээр сургаж бэлтгэх талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн
- o Сум, орон нутгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж , байгууллага, ажил олгогч бүрийн судалгааг гаргаж мэдээллийн сан бүрдүүлэлт
- o Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Сум хөгжүүлэх сан болон бусад төслийн шугамаар хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, олгосон зээлийн хэмжээ
- o Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Сум хөгжүүлэх сан болон бусад төсөл хөтөлбөрийн зээл тусламжийн үр дүнг тооцсон байдал
- o Малжуулах төсөлд хамрагдаж амьжиргаагаа дээшлүүлсэн өрхийн тоо
- o Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хөдөлмөр эрхлэлтийн төсөлд хамруулсан байдал, хамрагдсан иргэдийн тоо
- o Орон нутагт төр хувийн хэвшлийн түншлэлийг хангаж авсан арга хэмжээний үр дүн